



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Батламжийн загвар
шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагад олгох батламжийн загварыг хавсралтаар баталсугай.
2. Эрүүл мэндийн байгууллагад олгох батламжийг хэвлүүлэх зардлыг холбогдох зардлын зүйл ангиас гаргахыг ерөнхий нягтлан бодогч (С.Должинсүрэн)-д зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга (Д.Оюунчимэг)-д үүрэг болгосугай.

САЙД



Н.УДВАЛ

001623

2

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
01 сарын 18-ны өдрийн дүгээр
тушаалын хавсралт



Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн
байгууллагад олгох батламжийн загвар

Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагад олгох батламж нь дараах
загвартай байна:

1. Батламж нь 40 х 50 см (том), 20 х 30 см (жижиг) хэмжээтэй, усан хээн нууцлалтай, цайвар шаргал өнгийн соёмбо бүхий дэвсгэртэй, захаараа бор өнгийн өлзий хээн хүрээтэй байна.
2. Батламжийн дээд хэсэгт Эрүүл мэндийн яамны логог байрлуулж, түүний доод хэсэгт "БАТЛАМЖ" гэж бичсэн байна.
3. Батламж нь дугаартай байна. Дугаарыг нэгж, аравт, зуутын оронтой тоогоор тэмдэглэх ба батламж олгосон огноог бичнэ.
4. Батламж нь дараах байдлаар бичигдэнэ.

/ Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын нэр/
.....
..... нь

**Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний технологи,
чанарын шаардлага хангасныг**

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭВ.

201 ... оны ... сарын ... өдөр хүртэл хүчинтэй

САЙД

201

/магадлан итгэмжлэлийн эхлэх он, сар, өдөр/

5. Батламжид Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гарын үсэг зурж, баталгаажуулна.
6. Том батламж нь 45 х 55 см хэмжээтэй жаазтай байна.
7. Батламжийн зүүн доод хэсэгт Эрүүл мэндийн яамны логог сийлсэн нууцлалын тэмдэг байна.



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ

БАТЛАМЖ

Дугаар 123/2013

УЛААНБААТАР СОНГО ОМНОЛЭГ нь

**Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний
технологи, чанарын шаардлага хангасныг
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭВ.**



201 _ оны _ сарын _ өдөр хүргэл хүчинтэй

САЙД

Н.УДВАЛ

201 _ . _ . _